

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дагвадорж	Дугаар	L176
Оршин суугаа аймаг	Говь-Алтай	Оршин суугаа сум	Чандмань
Төрсөн газар	Чандмань сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Чандмань сумын Засаг дарга		
Лам байсан эсэх, Шавилан сүүж байсан сүм хийд	Хүрхрээгийн хийд, Өлзийт булагийн хийд	Сүм хийдийн дугаар	ГАЧН 095, ГАЧН 098
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 22	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Чандмань сумын
Хүрхрээгийн хийд, Өлзийт булагийн хийд

Асуулт:-**Ингээд та** бидэнд тус сумын нутагт байсан хийдүүдийн тухай ярьж өгнө үү.

Хариулт:-Манай суманд 1937 оноос өмнө 3 хийд байсан. **Хүрхрээгийн хийд, Өлзийт булагийн хийд, Ганхадын жас** гэж жас байсан байгаа юм. Тэр үед нийтдээ 3 шашин номын газар байсан гэж үздэг. **Хүрхрээгийн хийд** бол 1700 оны үед үүссэн байх магадлалтай, 37 он хүртэл 3 хамбын нүүр үзсэн ийм хийд байсан. Анх байгуулсан хүн нь Самдан гэдэг хүн байгуулсан гэж ярьдаг. Тэр хүн бол энэ суманд шилийн сайн эр байж байгаад, зүүн тийшээ яваад алга болсон. Тэгээд 10-аад жилийн дараа эргэж ирж сайн лам болж ирсэн юм байна лээ гэж. Тэрний хөрөнгийг **Хүрхрээгийн** жасын хөрөнгийг Диваажин тайж гэдэг тасдаж өгч байсан юм гэнэ лээ. Энд 100 хонь, 1 ямаа тасдаж өгч байсан,гэрийг нь барьж өгч байсан. Диваажин тайж, Самдан хоёр бол шилийн сайн эр байхдаа

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хамтарч ажилладаг байсан ийм улсууд юм шиг байгаа юм. Тэгээд сүүлдээ нэг нь лам болж, нөгөө нь жасын мал маллаж байсан ийм түүхтэй юм билээ.

Тэрний дараа хэлмэгдүүлэлтийн үед 37 онд Дондов унзад гэж 70 настай хүн байсан байгаа юм. Тэр хүн дуу их сайхантай тийм лам байсан гэж шавь нар нь ярьдаг байсан. **Хүрхрээгийн** хийдийн шавь нар саяхан болтол байлаа. 90 онд **Хүрхрээгийн** хийдийг дахин сэргээсэн. Энд лам Галсан гэдэг хүн, лам Дуламсүрэн, бариач Аюуш, ард Содном гэх мэтийн хүмүүс санаачилга гаргаж анх хийдийг дахин сэргээсэн ийм түүхтэй юм.

Өлзийт булагийн хийд бол 1750-иад оны үед байгуулагдсан юм шиг байгаа юм. Энэ анх байгуулагдахдаа хэд хэдэн газар байгуулагдаж байсан ийм түүхтэй юм байна лээ. Бүрдэн голд Ерийн хийд гэж байж байгаад, цаашаа бас тэр үед үймээн самуун гараад сүмийн хутаг гэж байгуулагдаад, эцэст нь **Өлзийт булагийн** хийдэд төвлөрч байсан. 1937 онд Баасан лам гэдэг хүн толгойлж байгаад, 30 гаруй лам байсан юм шиг байна лээ. Энэ талаар Соном гээд хүн бий, настай хүн бий, 80 гарсан. Тэр чиглэлээр тэр сайн мэдэж байгаа. **Өлзийт булагийн** хийд дээр хамгийн сүүлчийн лам нь Гунгаа гэж 2001 оны үед нас барсан. Шавилж байсан хувилгаан хүн байсан. Хувилгааны хамгийн сүүлийн дүр.

Өлзийт булагийн хийдэд 30, 40-өөд лам байсан юм шиг байгаа юм. Анх байгуулагдсан түүхийг сайн мэдэхгүй байна. Ер нь 37 онд тарсан. Одоо туурь нь байж байдаг, ламынх нь гэрийн буурь бүгд бий. Ламынх нь хэрэглэж байсан баганан чөлүү ийм юмнууд нэлээн хадгалагдаж үлдсэн байдаг юм. **Өлзийт булагийн** хийдийн түүрийн тухайд бол.

Яг энэ чиглэлээр Соном гэдэг хүнтэй уулзвал нэлээн тодорхой ярьж өгөх байлгүй дээ. Миний мэдэж байгаа энэ. **Ганхадын** жас бол сүүлд байгуулагдсан. 37 **оноос өмнө тарчихаж** байсан юм гэнэ лээ. Энд 7, 8 хүн шавилан суудаг байсан, ах дүү 4 гэлэн байгуулж байсан, тэгээд тэнд нь ойролцоо нь хүн хөлдөж нас бараад тэгээд тэнд чөтгөртэй болсон гэж үзсэний улмаас тэр жас тарж байсан юм байна лээ.

Асуулт:-**Хүрхрээгийн дуганын** лам нар ямар уулаа тахидаг байсан юм бол?

Хариулт:-**Хүрхрээгийн** овоо гэж байна. Бутны овоо гээд байдаг юм. Тэрнийг тахиж байсан, цагаан овоо байсан. Одоо бол тэр овоогоо тахидаг. Дээр нь **Борхайрханыг** тахидаг байсан. Саяхан овоо тахидаг судар нь тэр овоон дотроос гарч ирсэн юм. Тэр лам нар тэрүүгээр нь уншиж тахиад хадгалагдаж байдаг Улаанбаатар хотод Лхагва гэдэг лам бий. Эрдэнээ бол сайн мэдэж байгаа. Тэр хүн энүүгээр сая явж байна лээ.

Асуулт:-Ямархуу маягаар тахидаг байсан юм бол, цагаан идээгээр **тахид**г байсан уу?

Хариулт:-Цагаан идээгээр тахидаг байсан юм гэнэ лээ. Мөн Төмөр хавыг тахидаг байсан гэнэ лээ. Гунаа гээд хөгшин байдаг шүү дээ, 22-ын товчооны наад талд гэртэй, тэр **Хүрхрээгийн** хийдэд шавилан сууж байсан. Тэр хүн тэр **Хүрхрээгийн** хийдийн асуудлаар нэлээн тодорхой ярих байх. Зун тахидаг байсан. Төмөр хавийн овоог бас тахиж байсан юм гэнэ лээ. Тэгээд нэг жил их ган болоод тэгээд Дондов унзад өөрөө тахиж байсан гэж Гунаа гүай ярьж байсан. Очиж тахихдаа асар их том могой гарч ирсэн. Овооноос нь. Тэгээд тэр могойг бол бүх лам нар чимээгүй бол гээд тэр унзад нь. Тэгээд өөрөө ганцаараа номоо уншаад тэгээд тэр тойрч тойрч байгаад эргээд орсон. Тэгээд эргээд оронгуут нь номоо унш гэж шавь нараа хэлээд тэгээд тэр могой орсон газрыг нь

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

дарж байсан юм гэнэ лээ. Лус их догшин хүлээж авч байна, асар их ширүүн бороо орж тэгж байсан. Тэгээд надаас хойш битгий тахиж байгаарай гэж хэлж байсан гэж Гунаа гуай надад ярьж байсан.

Асуулт:-**Хүрхрээгийн** хийд шарын урсгал байсан уу, улааны урсгал байсан уу?

Хариулт:-Шарынх байсан.

Асуулт:-Тэр хийд **Ганжуур, Данжуур** гээд томоохон судар байсан болов уу?

Хариулт:-Байсан байхаа. **Зодын** судар байж байгаад, хамгийн сүүлд Дондов **унзадын** зээ нь зод тавьдаг хүн байсан юм шиг байна лээ.

Асуулт:-Тэгвэл бас улааны урсгал байсан юм шиг байна.

Хариулт:-Тийм. Байсан байхаа. Зод тавьдаг байсан. Тэр **зодын** судар нь бүгд энэ хийддээ үлдсэн байгаа.

Асуулт:-Энэ хийдэд номоо барладаг бар байсан болов уу?

Хариулт:-Мэдэхгүй. **Хүрхрээгийн** хийдэд байдаг байхаа Саарал ахын ном. Тэр авдран дотор нь бар байсан санагдаж байна. Тэгэхээр бартай байсан байх.

Асуулт:-**Хүрхрээгийн** хийд дээр цам, Майдар эргэдэг байсан уу?

Хариулт:-Майдар эргэнэ гэж юм ярьдаг юм байна лээ, тэр чухам яг юуг болдог байсныг мэдэхгүй. Ер нь **тэр** асуудлаар Гунаа гэдэг хүнтэй уулзвал 22-ын товчооны наад талд байдаг юм. Дуган шиг юм байдаг шүү дээ, тэрний хажууд жижиг гэрт 80 хэдтэй хүн байгаа. Тэр яг **Хүрхрээгийн** хийд дээр шавилан сууж байсан байгаа. Дондов **унзадын** шавь юм гэнэ лээ. Улаанбаатарт бас Хайдав гэж байгаад нас барчихлаа. **Хүрхрээгийн** хийдэд сууж байсан улсууд их олон байна л даа. Бигэрт **Жамбалжанжаа** гэж байгаад бас 80 хэдтэй, нас барчихсан. Одоо ганц Гунаа гуай л үлдсэн.

Энд одоо Говь-Алтайн хэдэн лам нар чинь үндсэндээ манай сумаас гаралтай лам нар байна шүү дээ.